

САЙНЦАГААН СУМЫН “ЭРҮҮЛ ХОТ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

2018.06.13.

№	Аргахэмжээ	Хийх ажил	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.Иргэний газар өмчлөх болон эзэмших эрх, түүнтэй холбоотой зөрчил маргааныг шийдвэрлэх.					
1	1. Айл өрх болон ААНБ-ын газрын хэмжээний зөрүүг арилгах.	1.Баг бүрээс сонгогдсон 1 гудамжны айлуудын газрын зөрүүтэй эсэхт хэмжилт хийх.	-зөрчлийг 80%-иар бууруулсан байх	Төвийн 5 багаас сонгогдсон 50 гудамжны 223 өрхөд газрын зөрүүтэй эсэхэд хэмжилт хийн зөрчилтэй 6 айлын газрыг татууллаа.	70
		2.Газрын зөрүү, маргааныг шийдвэрлэх.		Газар эзэмшээд 2 жил ашиглаагүй, гэрээний биелэлт хангаагүй 1 иргэн, 1 ААН-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болголоо.	40
	2.Гэрхорооллын гудамжыг жигдрүүлэх, нэгэн жигд болгох хөдөлгөөн өрнүүлэх.	3. Баг бүрээс 2 гудамжыг сонгож айл өрхүүдтэй нь уулзалт зохион байгуулах.	- баг тус бүр 2 гудамжыг жигдрүүлэх	Баг бүрээс 2 гудамжийг сонгон иргэдэд Газрын тухай, Зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа. Уг сургалтанд 46 иргэн хамрагдлаа.	70
		4. Газраа өөрсдөө дураар тэлсэн айлуудад албан шаардлага тавьж гудамжыг нэгэн жигд болгох.	-баг бүр нийт айл өрхийн 50-аас доошгүй хувийг зосдуулна.	Иргэдээс ирсэн гомдлын дагуу 3 айлд албан шаардлага өгч хашааг татуулан янзлууллаа.	70
	3. Гэр хорооллын айлуудын хашаануудыг зосдох	5.Айраг, Мандал, Нарлаг багийн хэрэгцээнд 30 тн зос бэлтгэж өгөх.		Айраг, Мандал, Нарлаг багт нийт 30 тн зос татаж багийн дарга нартай хамтран айл өрхийн хашааг зосдуулах ажлыг хийж, одоогийн байдлаар Мандал-53, Айраг-40, Боржигон-36, Арвижих-48 нийт-177 өрх хашаагаа зосдлоо.	40
	4. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн урт үргэлжилсэн гудамжинд явган хүний гарц гаргах.	6.Гарц гаргах шаардлага хэрэгцээг судлах.	-судалгаанд үндэслэн гарц гаргасан байх.	Эхний ээлжинд гарц гаргах шаардлагатай 7 гудамжны судалгааг багийн дарга нартай хамтран гаргалаа.	70
		7. Нарийн гудамж гарц гаргах ажилд багийн ИНХурлын төлөөллөөс оролцуулж гарц гаргах гудамжны айлуудтай уулзаж тохиролцох.		Багуудад гарц гаргах талаар БИНХ-ын дарга, тэргүүлэгч нартай уулзалт хийж, гарц гаргах хэрэгцээт гудамжны талаар ярилцаж Нарлаг багийн 2-р гудамж, Мандлын 12-15-р гудамж, Арвижих багийн зоогийн-9, шанд-4, Шанд-7, Зоог-11 гудамжны өнцөг залгаа гудамжны иргэдтэй уулзан тохиролцож, нийт 4 гарц гаргалаа.	70
	5. Газар эзэмшүүлэх болон өмчлөх өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.	8.Иргэдийн өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэх.	-өргөдөл гомдлыг хугацаа алдалгүй шийдвэрлэх.	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 5 сарын байдлаар сумын хэмжээнд 1003 иргэнд 83,2 га газрыг аймгийн Засаг даргын захирамжаар өмчлүүллээ. Газар өмчлөлийн явц 51,3 хувьтай байна. Мөн үетэй харьцуулахад 65,2%-иар нэмэгдлээ.	70

	6. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг иргэдэд сурталчилах.	9.Багийн иргэдийн нийтийн хуралд мэдээлэл хийх.	-9 багийн ИНХуралд мэдээлэл хийх.	Төвийн багийн нэгдсэн өдөрлөг болон багийн хурлуудад Эрүүл хот дэд хөтөлбөр талаар болон Газрын тухай хуулийг давхардсан тоогоор 520 иргэнд мэдээлэл хүргэлээ.	70
		10.АС цогцолбороор мэдээлэх.	-Мэдээлэл хийсэн байх	АСА цогцолбороор эрүүл хот дэд хөтөлбөрийн талаар хийгдэж байгаа болон цаашид хийгдэх ажлын талаар 6 удаа 20 минутын мэдээлэл хийлээ.	100
		11. Аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгуулах.		Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн талаар 8 ААН-ийн 160 албан хаагчдад мэдээлэл хийлээ.	100
Нийт хэрэгжилт- 70%					
2. Хотын төвд байгаа хуучирсан барилга байгууламжид хяналт тавих.					
2	1.Багуудын нутаг дэвсгэрт байгаа ашиглалтгүй барилга байгууламжыг фото зургаар баримтжуулах	12.Ашиглалтгүй барилга байгууламжийн судалгааг гаргах.	-барилгын судалгаа гаргасан байх.	Төвийн багийн дарга нартай хамтран ашиглалтгүй /4 /барилга байгууламжийн судалгааг гарган,зурагжуулан Аймгийн ЗДТГ-т хүргүүлээ.	100
		13.ГХБХБГазартай хамтран эзэмшлийг тогтоох.	Барилга байгууламжийн эздийг тодруулах	Ажлын хэсгийн гишүүд газрын албатай хамтран ашиглагддаггүй 4 барилга байгууламжийн эздийг тогтоолоо.	100
	2. Өнгө үзэмж муутай байр, орон сууцны гадна талыг иргэдийн оролцоотойгоор засаж сайжруулах.	14. ГХБХБГазраар жишиг загвар зургийг гаргуулж авах.	-төвд байрлалтай байрнуудад засвар хийгдсэн байх.	Хотын төвд байгаа үзэмж муутай хувийн сууцнуудыг гадна талын пасадны загвар гарган жигдрүүлэхээр төлөвлөгөө гаргалаа. Мөн төвийн 5 багийн дарга нартай хамтран багт ашиглагддаггүй 4 барилга байгууламжийн эздэд засаж сайжруулах мэдэгдлийг хүргүүлээ.	70
	3. Шинээр баригдаж байгаа барилгад хяналт тавих.	15.Элс хайрганы гэрээ байгуулж,барилгын хаягдал болон шороог хогийн нэгдсэн цэгт буулгуулах	-барилгын ажлын үлдэгдэл шороо, шороон даланг тэгшилж хөрсийг эрүүлжүүлэх.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын гэрээг 3 иргэн, ААН байгууллагуудтай байгууллаа.	70
	4. Багуудын нутагт байгаа хуучин хүүхдийн тоглоомын талбайг иргэдийн оролцоотой засварлах.	16.Засварлах шаардлагатай тоглоомын талбайг сонгож Багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон иргэдийн дэмжлэгээр засаж материалыг бэлтгэж хийж дуусгах.	Нарлаг баг 1, Айраг баг 1, Арвижих баг 1, Боржигон баг 3, Мандал баг 1 хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулна.	Засварлах шаардлагатай хуучирсан тоглоомын 7 талбайг хамтран засварлаж шинэчлэх саналыг тухай багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг харъяа 5 ААНэгж байгууллагуудад хүргүүлж уулзалт зохион байгууллаа. Одоогийн байдлаар Боржигон багийн 1-р гудамжны үзүүрт байрлах тоглоомын талбайг засах ажил хийгдэж байна.	70
	5. А зэрэглэлийн бүсэд байгаа хуучны амбар болон контейнерыг хотын төвөөс гаргах.	17.Мэдэгдэл хүргүүлж хяналт тавих Нарлаг багийн нутагт байгаа 4 контейнер, 2 амбаарыг хотын төвөөс гаргах.	-зөвшөөрөлгүй нийтийн эзэмшлийн талбайд байрлуулсан амбар болон контейнерыг	А зэрэглэлийн бүсэд байрлах 4 контейнер, 2 амбаарыг хотын төвөөс гаргах хугацаатай мэдэгдэх хуудсыг Газрын албатай хамтран эздэд хүргүүлээ.	70

			хотын төвөөс гаргасан байх.		
Нийт хэрэгжилт-80%					
3.Хогийн менежментийг сайжруулах.					
3	1.Гэр хорооллын айл өрхүүд хог ачилтыг тогтмолжуулж хуваарь гарган хэвшүүлэх.	18.Хог тээврийн автомашинуудыг багуудад хуваарилах.	Хуваарь гаргаж тогтмол ачидаг байх	Төвийн 5 багт хог тээвэрлэх авто машин, жолооч, ачигч тус бүрийг хуваарилалаа.	100
		19.Сард 1-2 удаа айлуудын хогийг ачих.		Хот тохижуулах ОНӨААТҮГазартай хамтран айл өрхийн хогийг сар бүр тогмол ачих график, төлөвлөгөө гарган ажиллаж байна.	70
	2.Гудамжинд ил задгай хог болон угаадас асгадаг иргэдэд хариуцлага тооцох.	20. Сумын төрийн сангаар үнэт цаас гаргуулж хэвлүүлэн багийн дарга нарт өгч Баг бүр 10-аас доошгүй айлд хариуцлага тооцох.	Хариуцлага тооцсон өрхий тоо	Баг тус бүр хагас жилийн хугацаанд ил задгай хог, угаадас асгасан 14 өрхөд мэдэгдэл хүргүүлээ. Арвижих-3, Боржигон-6, Айраг-5 өрхөд.	70
	3.Айл өрх болон ААНБ-д зориулалтын хогийн сав гаднаа байрлуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах.	21. Зориулалтын хогийн савтай болох тухай Аймгийн засаг даргын захирамжийг хэрэгжүүлж ажиллах.	-хогийн савны тоо нэмэгдсэн байх. -айл өрхүүд хогийн	Аймгийн засаг даргын захирамжийн дагуу зориулалтын 8 хогийн савыг төв саад болон төв замын хажуу талаар байрлуулалаа.	70
		22. Гадна талдаа хогийн савгүй аж ахуйн нэгж байгууллагад шаардлага тавих.	Сав шинээр хийж байршуулсан байх.	Хотын төвд болон гэр хороололд байрлалтай ААНэгжүүдэд гаднаа хогийн савтай болох шаардлагыг тавьж одоогийн байдлаар 18 ААНэгж ангилан ялгах хогийн савтай боллоо.	100
	4.Хог хаягдлын тухай хууль болон ангилан ялгалт дахин ашиглалтын талаар сургалт зохион байгуулах.	23.Багийн ИНХурлуудад мэдээлэл хийх.	Сургалт зохион байгуулагдсан байх	Багуудын ИНХуралд болон төвийн багуудын нээлттэй мэдээллийн өдрөөр нийт-520 гаруй иргэдэд хог хаягдлын тухай хуулийг танилцуулж, гарын авлага материал тараалаа. Мөн ангилан ялгах хогийн савны загвар танилцуулан эхний ээлжинд багууд 1 гудамжийг жигд адил хогийн савтай болох талаар ярилцлаа.	100
		24.Сургуулийн сурагчид болон төрийн байгууллагын ажилчдад мэдээлэл хийх.		ЕБС-ийн 135 сурагч, 7 байгууллагын 63 ажилчин алба хаагч нарт Эрүүл хот дэд хөтөлбөрийн талаар яриа таниулга хийж хог хаягдлын тухай хууль, Эх дэлхийгээ хайрлая сэдэвт сургалтыг зохион явуулалаа.	100
	5.Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах.	25.Бүх нийтийн цэвэрлэгээний хуваарь, зураглал гаргаж Хог цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	оролцуулж, олон хүн хамруулсан байх.	Албан байгууллага аж ахуй нэгжүүд ойр орчмын 50м газрыг цэвэрлэж, эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх график зураглал гарган төвийн 5 багт хувиарлан 2 удаа их цэвэрлэгээнд гарч 119 тн хогийг ачиж цэвэрлүүлээ. Мөн ХХҮГазар, Хот тохижуулах газартай хамтран нийтийг хамарсан ажилд сар тутам 20 иргэнийг ажилуулан хотын төвийн хог хаягдлыг өдөр тутам цэвэрлүүлж байна.	100

	6.Хог шатааж байгаа иргэн ААНБайгууллагад хариуцлага тооцож хяналт тавьна.	26.Хог хаягдлын тухай хууль, Зөрчлын тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авах.	-хог хаягдлын тухай хуулийг сурталчилах -торгуулийн арга хэмжээ авсан байх.	Хогтой элс асгаж байсан 1 иргэнд зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэхь заалтын дагуу 50.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авлаа.	70
Нийт хэрэгжилт-86,6%					
4. Бүтээн байгуулалт					
4	1.Гэр хороолол болон хотын төвд гэрэлтүүлэг нэмэж хийнэ.	27. Нарлагын 8 гудамжинд 6ш гэрэлтүүлэг хийх.	-гэрэлтүүлэг нэмэгдсэн байх.	Нарлагийн 8-р гудамжинд 6 ш гэрэлтүүлгийг оршин суугчдын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэлээ.	100
		28. Мандалын 12 гудамжинд 25 ш гэрэлтүүлэг хийх.		8-р сард хийгдэхээр төлөвлөлөө.	-
		29. МТ ШТС-аас Буянт гүүр хүртэл гэрэлтүүлэг хийх.		Аймгийн ОНХС-аар Буянт гүүрнээс МТ-ШТСанц хүртэлх гадна гэрэлтүүлгийг “Анарзнь” ХХКомпани хийж гүйцэтгэлээ.	100
	2.Нийтийн эзэмшлийн талбайг засаж тохижуулах.	30. ГБХЗХГазарын зүүн талд усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.	-усан оргилуур хийгдсэн байх.	Сумын ОНХСангийн 36,4 сая төгрөгний хөрөнгөөр аймгийн төвд байрлах “Мангасын ам” тоглоомын талбайг шинээр тохижуулж, орчин үеийн тоглоомын талбайг аймгийн баяр наадмаас өмнө ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Уг ажлыг хэрэгжүүлэх хүрээнд зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, үнэлгээний хороог байгуулах зэрэг бэлтгэл ажлыг хангаж байна.	70
	4.Зарим цэцэрлэгийн гадна гэрэлтүүлэгийг	31. 2, 3, 4, 5, 6, 7-р цэцэрлэгийн гадна талд гэрэлтүүлэгд нэмж байршуулна.	гадна гэрэлтүүлэгтэй болсон байх.	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаж шалгарсан ХХК-д дүгнэлтийг хүргүүлээ.	70
	5.Аймгийн төвийн хаягжуулалтыг шинэчлэх	32.Шинээр мөрдөгдөх хаягжуулалтын урьдчилан ирүүлсэн төсөлтэй танилцаж тулгалт хийх.	-гэр хороолол болон хотын төвийн орон сууцны хаягжуулалт хийгдсэн байна.	Шинээр мөрдөгдөх хаягжуулалтын урьдчилсан төсөлтэй танилцаж, тулгалтыг газрын албатай хамтран гүйцэтгэлээ.	40
Нийт хэрэгжилт-76%					

Нийт хэрэгжилт-75,4 %

САЙНЦАГААН СУМЫН ЗДТГАЗАР